



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өгийнуур сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/63/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Архангай аймаг  
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа  
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар  
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Алтанчимэг  
Утас: 90060105 Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитындүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.9 Завсрын аудитын үр дүн .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

## 2.Аудитын дүгнэлт



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

᠋᠋᠋ ᠋᠋᠋ № ᠋᠋  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ӨГИЙНУУР СУМЫН ЗДТГ-ЫН  
ДАРГА Д.ТҮВШИНБААТАР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өгийнуур сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өгийнуур сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>36,289,349.00</u></b>	<b><u>43,578,149.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	36,289,349.00	43,578,149.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	36,289,349.00	43,578,149.00
35410	Бичиг хэргийн материал	294,000.00	263,100.00
35420	Аж ахуйн материал	35,995,349.00	43,315,049.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,018,963,628.82</u></b>	<b><u>979,298,512.22</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,018,963,628.82	979,298,512.22
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	978,562,228.90	939,397,112.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	384,062,285.30	384,062,285.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(60,297,946.42)	(79,684,346.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	169,560,517.00	169,560,517.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(49,469,458.48)	(77,957,389.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,801,065.00	36,604,065.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,577,314.82)	(19,461,138.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,361,777.77	35,221,681.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,287,934.01)	(24,004,035.13)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,800,000.00	1,800,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	680,642,890.20	746,892,890.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(187,033,652.64)	(233,637,416.04)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	40,401,399.92	39,901,399.88
39301	Програм хангамж	2,500,000.00	2,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,000,000.08)	(1,500,000.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	38,901,400.00	38,901,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,055,252,977.82</u></b>	<b><u>1,022,876,661.22</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,055,252,977.82</u></b>	<b><u>1,022,876,661.22</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,055,252,977.82	1,022,876,661.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	430,576,401.37	430,576,401.37
51101	Өмч: - төрийн	430,576,401.37	430,576,401.37
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	359,297,786.93	326,921,470.33
51210	Өмнөх үеийн үр дүн	359,297,786.93	359,297,786.93
51220	Тайлант үеийн үр дүн	-	(32,376,316.60)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	265,378,789.52	265,378,789.52
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,055,252,977.82</u></b>	<b><u>1,022,876,661.22</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>738,662,185.75</b>	<b>500,436,810.25</b>

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>325,335,464.75</b>	<b>63,824,284.25</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	325,335,464.75	63,824,284.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	325,335,464.75	63,824,284.25
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,232,145.75	5,109,084.25
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	323,103,319.00	58,715,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>413,326,721.00</b>	<b>436,612,526.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	18,628,721.00	32,020,226.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	7,520,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,628,721.00	24,500,226.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	394,698,000.00	404,592,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	394,698,000.00	404,592,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>473,577,498.07</b>	<b>532,813,126.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>467,077,498.07</b>	<b>532,813,126.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	439,990,484.32	516,955,921.60
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	245,961,500.00	246,504,349.00
210101	Үндсэн цалин	245,961,500.00	246,504,349.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,840,000.00	32,020,760.00
210201	Тэтгэврийн даатгал	20,996,063.54	22,316,050.87
210202	Тэтгэмжийн даатгал	2,460,983.98	2,480,424.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,968,787.19	1,984,339.47
210204	Ажилгүйдлийн даатгал	492,196.09	476,358.76
210205	Эрүүл мэндийн даатгал	4,921,969.20	4,763,586.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,010,000.00	25,270,300.00
210301	Гэрэл, цахилгаан	7,741,400.00	9,932,100.00
210302	Түлш, халаалт	9,248,600.00	10,400,000.00
210303	Цэвэр, бохир ус	20,000.00	4,938,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,709,150.00	34,487,400.00
210401	Бичиг хэрэг	2,509,400.00	2,528,400.00
210402	Тээвэр, шатахуун	7,563,300.00	7,500,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,607,500.00	1,991,000.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,000,000.00	15,550,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,928,950.00	6,817,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,735,800.00	795,500.00
210502	Хоол, хүнс	-	795,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,011,240.00	1,650,000.00
210604	Урсгал засвар	796,240.00	1,650,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,470,000.00	2,350,000.00
210702	Дотоод албан томилолт	2,470,000.00	2,350,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,310,263.00	2,211,076.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,765,421.00	1,269,626.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	466,524.00	386,524.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00

210807	Газрын төлбөр	28,318.00	4,926.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>107,942,531.32</b>	<b>171,666,536.60</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,106,500.00	62,491,220.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,143,000.00	895,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,693,031.32	108,280,316.60
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,087,013.75</b>	<b>15,857,205.25</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>20,839,700.00</b>	<b>1,500,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,247,313.75</b>	<b>14,357,205.25</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,247,313.75	14,357,205.25
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>265,084,687.68</u></b>	<b><u>(32,376,316.60)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	430,576,401.37	265,378,789.52	96,313,099.25	792,268,290.14
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>430,576,401.37</b>	<b>265,378,789.52</b>	<b>96,313,099.25</b>	792,268,290.14
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	262,984,687.68	262,984,687.68
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	430,576,401.37	265,378,789.52	<b>359,297,786.93</b>	1,055,252,977.82
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	430,576,401.37	265,378,789.52	<b>359,297,786.93</b>	1,055,252,977.82
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	430,576,401.37	265,378,789.52	<b>359,297,786.93</b>	1,055,252,977.82
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(32,376,316.60)	(32,376,316.60)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	430,576,401.37	265,378,789.52	<b>326,921,470.33</b>	1,022,876,661.22

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>415,558,866.75</u></b>	<b><u>441,721,610.25</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,232,145.75</b>	<b>5,109,084.25</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,232,145.75	5,109,084.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,232,145.75	5,109,084.25
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,232,145.75	5,109,084.25
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>413,326,721.00</b>	<b>436,612,526.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	18,628,721.00	32,020,226.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	7,520,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,628,721.00	24,500,226.00

<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	394,698,000.00	404,592,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	394,698,000.00	404,592,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>401,860,866.75</u></b>	<b><u>427,521,610.25</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>401,860,866.75</b>	<b>427,521,610.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>374,773,853.00</b>	<b>411,664,405.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	245,961,500.00	246,504,349.00
210101	Үндсэн цалин	245,961,500.00	246,504,349.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,840,000.00	32,020,760.00
210201	Тэтгэврийн даатгал	20,996,064.00	22,316,050.87
210202	Тэтгэмжийн даатгал	2,460,984.00	2,480,424.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,968,787.00	1,984,339.47
210204	Ажилгүйдлийн даатгал	492,197.00	476,358.76
210205	Эрүүл мэндийн даатгал	4,921,968.00	4,763,586.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,010,000.00	25,270,300.00
210301	Гэрэл, цахилгаан	7,741,400.00	9,932,100.00
210302	Түлш, халаалт	9,248,600.00	10,400,000.00
210303	Цэвэр, бохир ус	20,000.00	4,938,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,605,550.00	34,526,200.00
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,497,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,563,300.00	7,500,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,607,500.00	2,191,000.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,000,000.00	16,918,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,834,750.00	5,318,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,735,800.00	795,500.00
210502	Хоол, хүнс	-	795,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,546,240.00	4,600,000.00
210604	Урсгал засвар	1,296,240.00	4,600,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,470,000.00	2,350,000.00
210702	Дотоод албан томилолт	2,470,000.00	2,350,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,310,263.00	2,211,076.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,765,421.00	1,269,626.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	466,524.00	386,524.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
210807	Газрын төлбөр	28,318.00	4,926.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	40,294,500.00	63,386,220.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,151,500.00	62,491,220.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,143,000.00	895,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,087,013.75</b>	<b>15,857,205.25</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,839,700.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,247,313.75	14,357,205.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,247,313.75	14,357,205.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b>13,698,000.00</b>	<b>14,200,000.00</b>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<b>13,698,000.00</b>	<b>14,200,000.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<b>13,698,000.00</b>	<b>14,200,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	13,698,000.00	14,200,000.00
220001	Барилга байгууламж	6,500,000.00	13,200,000.00
223001	Бусад хөрөнгө	2,698,000.00	1,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b>(13,698,000.00)</b>	<b>(14,200,000.00)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	406,592,300.00	395,907,379.00	10,684,921.00	97.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,392,300.00	382,707,379.00	10,684,921.00	97.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	391,892,300.00	381,207,379.00	10,684,921.00	97.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,542,100.00	246,504,349.00	37,751.00	99.98
210101	Үндсэн цалин	246,542,100.00	246,504,349.00	37,751.00	99.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,283,200.00	32,020,760.00	1,262,440.00	96.21
210201	Тэтгэврийн даатгал	23,421,600.00	22,316,050.87	1,105,549.13	95.28
210202	Тэтгэмжийн даатгал	2,465,400.00	2,480,424.30	(15,024.30)	100.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,972,300.00	1,984,339.47	(12,039.47)	100.61
210204	Ажилгүйдлийн даатгал	493,100.00	476,358.76	16,741.24	96.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,930,800.00	4,763,586.60	167,213.40	96.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,382,100.00	20,382,100.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	7,282,100.00	9,932,100.00	(2,650,000.00)	136.39
210302	Түлш, халаалт	13,000,000.00	10,400,000.00	2,600,000.00	80.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	50,000.00	50,000.00	50.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,114,800.00	27,107,300.00	7,500.00	99.97
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,497,500.00	2,500.00	99.90
210402	Тээвэр, шатахуун	7,000,000.00	7,000,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,196,000.00	2,191,000.00	5,000.00	99.77
210404	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,318,800.00	5,318,800.00	-	100.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	-	1,000,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	-	1,000,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,100,000.00	5,600,000.00	5,500,000.00	50.45
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	1,000,000.00	1,500,000.00	40.00
210602	Тавилга	4,000,000.00	-	4,000,000.00	0.00

210604	Урсгал засвар	4,600,000.00	4,600,000.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>2,350,000.00</b>	<b>650,000.00</b>	<b>78.33</b>
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,350,000.00	650,000.00	78.33
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,800,000.00</b>	<b>1,113,450.00</b>	<b>686,550.00</b>	<b>61.86</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	172,000.00	28,000.00	86.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	500,000.00	500,000.00	50.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	386,524.00	113,476.00	77.30
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	50,000.00	4,926.00	45,074.00	9.85
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>47,670,100.00</b>	<b>46,129,420.00</b>	<b>1,540,680.00</b>	<b>96.77</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,670,100.00	45,234,420.00	1,435,680.00	96.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	895,000.00	105,000.00	89.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,200,000.00</b>	<b>13,200,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>13,200,000.00</b>	<b>13,200,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
220001	Барилга байгууламж	13,200,000.00	13,200,000.00	-	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>406,592,300.00</b>	<b>395,907,379.00</b>	<b>10,684,921.00</b>	<b>97.37</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>404,592,300.00</b>	<b>390,798,294.75</b>	<b>13,794,005.25</b>	<b>96.59</b>
132001	Орон нутгийн төсвөөс	404,592,300.00	390,798,294.75	13,794,005.25	96.59
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2,000,000.00</b>	<b>5,109,084.25</b>	<b>(3,109,084.25)</b>	<b>255.45</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	5,109,084.25	(3,109,084.25)	255.45
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>25.00</b>	<b>25.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>25.00</b>	<b>25.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00	-	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>31,457,026.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>31,457,026.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>31,457,026.00</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,888,200.00</b>
210303	Цэвэр, бохир ус	4,888,200.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,418,900.00
210402	Тээвэр, шатахуун	500,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,918,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	795,500.00
210502	Хоол, хүнс	795,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,097,626.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,097,626.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,256,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,256,800.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	32,020,226.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	32,020,226.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,520,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,500,226.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өгийнуур сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Өгийнуур сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 5 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өгийнуур сумын ЗДТГ нь Дэлхийд нэртэй үзэсгэлэнт Өгийнуурынхаа байгалийн тэнцвэрт байдлыг хадгалан, аялал жуулчлал, бизнес үйлдвэрлэл хөгжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйтай биеэ даасан эдийн засагтай, ард иргэдийнхээ амьдрах таатай орчныг бүрдүүлж, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэсэн бүсийн загвар сум болох зорилготой үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өгийнуур сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 406.6 сая төгрөгөөс 1%-иар буюу 4.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 %-иар буюу буюу 2.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 39.7 сая төгрөгөөр буюу 4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
1	2	3	4=3-2	
Бараа материал	36.2	43.6	7.4	16.97
Үндсэн хөрөнгө	1019	979.3	-39.7	-4.05
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1055.2</b>	<b>1022.9</b>	<b>-32.3</b>	<b>-3.16</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1055.2	1022.9	-32.3	-3.16
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1055.2</b>	<b>1022.9</b>	<b>-32.3</b>	<b>-3.16</b>

3.5.1. Бараа материал эхний үлдэгдлээс 7.4 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 36.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 33.6 сая төгрөг, хандиваар 4.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж,

тайлант онд зарцуулсан 30.6 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 43.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2. Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 979.3 сая төгрөг буюу 39.7 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1019.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 14.2 сая төгрөгөөр, хандиваар 54.4 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 108.3 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 979.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.3 Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл тайлант хугацаанд -32.3 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

**Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт**

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	394.7	404.6	9.9
Нэмэлт санхүүжилтийн орлого	18.6	32.0	13.4
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	323.1	58.7	(264.4)
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>738.7</b>	<b>500.4</b>	<b>(238.3)</b>
Бараа үйлчилгээний зардал	107.9	171.7	63.9
Урсгал шилжүүлэг	27.1	15.8	(11.3)
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>467.1</b>	<b>532.8</b>	<b>65.7</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>262.9</b>	<b>(32.3)</b>	<b>(230.5)</b>

Өгийнуур сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны үр дүн өмнөх оноос 32.3 сая төгрөгөөр буурсан байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 561.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 155.1 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 406.6 сая төгрөгөөр хянаж баталжээ.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 406.6 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 395.9 сая төгрөгийн санхүүжилт авч 382.7 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж 10.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь урсгал зардлаас 10.6 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд иргэд болон байгууллагаас 7.5 сая төгрөгийн хандив, дээд шатны байгууллагуудаас 24.5 сая төгрөгийн санхүүжилтийн ирснээс 31.4 сая төгрөгийг зарцуулж 0.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Үүнээс:

1. Аймгийн Онцгой байдлын газраас 1.2 сая төгрөгийг коронавирус / ковид-19 / цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах майхан уулсын постын шатахуун, хоол хүнсний зардалд
2. Засгийн газраас усны төлбөрийг буцаан олгохтой холбогдуулсан 4.8 сая төгрөгийн буцаан олголт
3. Аймгийн Статистикийн хэлтсээс 0.9 сая төгрөгийг хагас жилийн мал тооллогын түүвэр тооллогын зардалд
4. Аймгийн ЗДТГ-аас 10.0 сая төгрөгийг коронавирус / ковид-19 / цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах зардалд
5. Аймгийн халамжийн хэлтсээс 0.2 сая төгрөгийг хүүхэд хамгааллын хамтарсан багт олгосныг шатахуун болон бичиг хэргийн зардалд
6. Аймгийн тамгын газраас 0.2 сая төгрөгийн цэрэг татлагын шатахууны зардалд
7. Аймгийн хөдөө аж ахуйн газраас 6.9 сая төгрөгийг байгальд халгүй энгийн механик аргаар үлийн цагаан оготной тэмцэх ажлын зардалд
8. Аймгийн ИТХ-с 0.3 сая төгрөгийг хүүхэд хамгааллын хамтарсан багт олгосныг буцаан төвлөрүүлсэн байна.

Иргэд байгууллагаас нийт 7.5 сая төгрөгийн хандив цугларснаас 7.2 сая төгрөгийг коронавирус / ковид-19 / цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах зардалд зарцуулж, 0.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Аудитын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант жилд ковид-19 цар тахал гарсантай холбогдуулан “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 15.1-д заасны дагуу сумын онцгой комисс өгсөн 7.2 сая төгрөгийн мөнгөн, 4.3 сая төгрөгийн мөнгөн бус хандивын нэмэлт санхүүжилтийн болон бараа материалын дансанд бүртгэж, голомтод ажилласан албан хаагчид болон ЭМТ, хэвтэн эмчлүүлэг нарын байр хоолны зардалд зарцуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээг 92.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 406.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 395.9 сая төгрөгийг зарцуулж, 97.3 хувийн биелэлттэй.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд урсгал зардлаас 10.6 сая төгрөгийн хэмнэлт гаргаж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нь батлагдсан төсвийн 10.0 хувийг эзэлж байна.
- Албан томилолт, бичиг хэргийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалтыг гаргасан байна.

2.Хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан ажил үйлчилгээний гэрээний хувьд: 1 хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулж 0.05 сая төгрөгийн зардал гарсан байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байхгүй тул судалгааг гаргаагүй байна

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өгийнуур сумын ЗДТГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд батлагдсан төсвийн 10.0 хувь буюу 10.6 сая төгрөгийн хэмнэлт бий болгож төсөвт буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт бүрэн нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өгийнуур сумын ЗДТГ санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг 2021.04.27-ны 21 тоот албан бичиг тоот бичгээр ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тээвэр шатахуун түлш халаалтын зардлын зарцуулалтыг шалгана

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

----oOo-----